

## ТАНИЛЦУУЛГА

### “ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАЛАЛГҮЙ ХҮНИЙ ОРШИН СУУХ ҮНЭМЛЭХ, ХАРЬЯАЛАЛГҮЙ ХҮНИЙ ЗОРЧИХ ҮНЭМЛЭХИЙН ЗАГВАР, ТЭДГЭЭРИЙГ ОЛГОХ ЭЗЭМШИХ, АШИГЛАХ, ХАДГАЛАХ ЖУРАМ”-Д ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ТУШААЛЫН ТӨСЛИЙН ТАЛААР

Хууль зүйн сайдын 2014 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/187 дугаар тушаалаар батлагдаж, Улсын нэгдсэн бүртгэлийн 2014 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 3497 дугаарт бүртгэгдсэн “Гадаадын иргэн, харьяалалгүй хүний оршин суух үнэмлэх, харьяалалгүй хүний зорчих үнэмлэхний загвар, тэдгээрийг олгох эзэмших, ашиглах, хадгалах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа танилцуулж байна.

1/ Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1-т дээр дурдсан журмыг батлах эрх зүйн үндсийг бүрдүүлж, зөрчсөн тохиолдолд мөн хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.12-т оногдуулах хариуцлагын талаар хуульчилсан.

Гэвч гадаадын иргэн оршин суух үнэмлэхээ гэмтээсэн, үрэгдүүлсэн тохиолдолд оршин суух үнэмлэхийг дахин олгох талаарх зохицуулалтыг журамд тусгасан боловч хүлээлгэх хариуцлагыг орхигдуулсан. Монгол Улсын иргэн нь иргэний цахим үнэмлэх болон үндэсний гадаад паспорт иргэний гэр бүлийн байдлын баримт бичиг олгох, эзэмших, хадгалах, шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Захиргааны хариуцлагын тухай хуулийн 27 дугаар зүйлд зааснаар иргэнийг 40000, албан тушаалтныг 60000 хүртэлх төгрөгөөр торгох шийтгэл оногдуулдаг эрх зүйн зохицуулалттай.

Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн нь тус улсын эрх бүхий байгууллагаас олгосон оршин суух болон зорчих үнэмлэхийг эзэмших, ашиглах, хадгалах журам зөрчвөл Монгол Улсын иргэний нэгэн адил хариуцлага хүлээх зарчмын дагуу дээрх журамд тусгасан тухайн зохицуулалтыг нэмэлт, өөрчлөлт оруулах замаар дэлгэрүүлэн томъёолж оруулсан ба орхигдсон зохицуулалтыг нэмж тусгалаа.

2/ Мөн Улсын Их Хурлын 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 12 дугаар тогтоол “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай”, Засгийн газрын мөн оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 4 дүгээр “Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолоор тус байгууллагын нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан Хууль зүйн сайдын 2014 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/187 дугаар тушаалаар баталсан дээрх журамд заасан байгууллагын нэршлийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болгон өөрчлөн орууллаа.

МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2016 оны ... дугаар  
сарын...-ны өдөр

Дугаар.....

Улаанбаатар  
хот

Журамд өөрчлөлт  
оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хууль зүйн сайдын 2014 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/187 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Гадаадын иргэн, харьяалалгүй хүний оршин суух үнэмлэх, харьяалалгүй хүний зорчих үнэмлэхийн загвар, тэдгээрийг олгох эзэмших, ашиглах, хадгалах журам”-ын 1.2-т заасан “...Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэснийг “гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж, хоёрдугаар хавсралтаар баталсан “Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсад оршин суух үнэмлэхний загвар”-ын 1, 3.1.13, 3.2.5, 5.4.1, гуравдугаар хавсралтаар баталсан “Харьяалалгүй хүн Монгол Улсад зорчих үнэмлэхийн загвар”-ын 12.1, 12.3-12.5-д заасан “Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар” гэснийг “Гадаадын иргэн, харьяатын газар” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Хууль зүйн сайдын 2014 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/187 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Гадаадын иргэн, харьяалалгүй хүний оршин суух үнэмлэх, харьяалалгүй хүний зорчих үнэмлэхийн загвар, тэдгээрийг олгох эзэмших, ашиглах, хадгалах журам”-ын 3 дугаар зүйл, 6.1, 12.1 дэх хэсгийг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/ ”3.1.Оршин суух үнэмлэхийг дараах тохиолдолд дахин олгоно. Үүнд:

- 3.1.1.гадаад паспорт солигдсон;
- 3.1.2.үнэмлэхээ гээсэн, үрэгдүүлсэн;
- 3.1.3.үнэмлэхний хүчинтэй байдлыг алдагдуулсан;
- 3.1.4.дүр төрхийн өөрчлөлт орсон;
- 3.1.5.хүйс өөрчлөгдсөн;

3.2.Оршин суух үнэмлэхийг дахин олгож өгөх тухай хүсэлт гаргагч дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна. Үүнд:

- 3.2.1.гадаад паспорт;

3.2.2.3x4 см 1 хувь гэрэл зураг;

3.2.3.оршин суух үнэмлэх дахин олгож өгөхийг хүссэн албан бичиг /хувь хүн бол өргөдөл/;

3.2.4.оршин суух үнэмлэхээ гэсэн, үрэгдүүлсэн болохыг зарлуулсан тухай болон холбогдох байгууллагын баримт;

3.2.5.оршин суух үнэмлэхний үнэ болон тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

3.3.Гадаадын иргэн, харьяалалгүй хүн энэ журмын 3.1-т заасан үндэслэлээр 3.2-т заасан материалыг бүрдүүлж өгснөөс хойш ажлын 5 өдөрт багтаан оршин суух үнэмлэх гаргаж өгнө.”

2/ “6.1. Оршин суух үнэмлэх нь тухайн гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн байцаалт болох тул биедээ байнга авч явах үүрэгтэй бөгөөд Газарт хураалгаснаас бусад тохиолдолд эзэмшигч өөрөө хадгална.”

3/ “12.1. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн энэхүү журмыг зөрчсөн, эсхүл оршин суух, зорчих үнэмлэхийг гэсэн, үрэгдүүлсэн, хүчинтэй байдлыг нь алдагдуулсан бол Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 42.1.12, 42.1.13-т заасан хариуцлага хүлээлгэнэ.”

3. Энэхүү тушаалын биелэлтийг хангаж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Гадаадын иргэн, харьяатын газар /Д.Мөрөн/-т үүрэг болгосугай.

САЙД

С.БЯМБАЦОГТ